



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/98/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт.....	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.24

№

50

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 193,284.0 мянган төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

4826050165

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 98.5 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,963,956.33	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	3,963,956.33	-
3121	Төгрөг	3,963,956.33	-
31218	Ахмадын сангийн харилцах	3,963,956.33	-
33	АВЛАГА	-	64,898,413.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,198,232.62
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	19,970,956.33
335	Бусад авлага	-	42,729,225.00
33510	Байгууллагаас авах авлага	-	5,929,225.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	36,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,158,331.04	26,552,231.04
351	Түүхий эд материал	7,440,221.04	7,440,221.04
35110	Тусгай зориулалттай материал	7,440,221.04	7,440,221.04
354	Хангамжийн материал	18,718,110.00	19,112,010.00
35410	Бичиг хэргийн материал	4,276,685.00	4,626,585.00
35420	Аж ахуйн материал	12,893,775.00	12,893,775.00
35430	Сэлбэг хэрэгсэл	16,500.00	16,500.00
35450	Барилгын засварын материал	1,531,150.00	1,575,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	577,074,246.02	716,521,809.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,074,246.02	716,521,809.04
392	Биет хөрөнгө	547,242,246.02	686,765,309.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,630,937.04	696,506,397.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,929,693.19)	(72,668,389.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,880,000.00)	(33,600,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,014,046.30	231,067,946.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(140,598,500.87)	(169,323,571.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,098,407.64	37,380,835.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,693,632.59)	(36,198,457.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	692.85	692.85
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11.16)	(145.08)
393	Биет бус хөрөнгө	29,832,000.00	29,756,499.94
39301	Программ хангамж	1,097,890.00	1,275,890.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(977,890.00)	(1,231,390.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,712,000.00	29,712,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	607,196,533.39	807,972,454.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,361,965.31	2,587,150.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,361,965.31	2,587,150.00
413	Өглөг	7,361,965.31	2,587,150.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,287,665.31	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	66,300.00	842,950.00
4136	Бусад өглөг	1,008,000.00	1,744,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,008,000.00	1,744,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	599,834,568.08	805,385,304.03
51	Засгийн газрын хувь оролцоо	599,834,568.08	805,385,304.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	387,540,211.70	387,540,211.70
51101	Өмч: - төрийн	387,540,211.70	387,540,211.70
512	Хуримтлагдсан үр дүн	66,453,356.55	272,004,092.50

51210	Өмнөх үеийн үр дүн	94,439,525.41	66,453,356.55
51220	Тайлант үеийн үр дүн	(27,986,168.86)	205,550,735.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,840,999.83	145,840,999.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	607,196,533.39	807,972,454.03

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,588,118,527.00	4,277,376,528.60
1310	Улсын төсвөөс	4,447,824,800.00	3,860,134,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,447,824,800.00	3,860,134,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	140,293,727.00	417,242,528.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,090,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	91,218,127.00	324,325,028.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	22,256,600.00	42,749,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,729,000.00	50,168,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	26,737,233.85	183,968,235.40
1200	Нийтлэг татварын бус орлого	26,737,233.85	183,968,235.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,840,885.00	95,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	67,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,773,685.00	95,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,896,348.85	183,873,235.40
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,614,855,760.85	4,461,344,764.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,643,096,929.71	4,255,794,028.05
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	861,878,189.61	1,102,023,178.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	585,621,456.15	778,905,515.16
210101	Үндсэн цалин	324,743,764.88	462,300,311.79
210102	Нэмэгдэл	160,563,184.19	206,748,380.29
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	48,388,197.58	58,144,029.97
210104	Урамшуулал	51,926,309.50	51,712,793.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,293,775.00	98,607,400.76
210201	Тэтгэврийн даатгал	50,451,175.00	68,566,365.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,460,700.00	7,734,894.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,730,299.52	4,352,944.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,730,300.48	3,870,782.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,921,300.00	14,082,413.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,286,730.52	32,008,919.92
210301	Гэрэл, цахилгаан	2,337,737.00	3,093,752.83
210302	Түлш, халаалт	29,683,100.52	26,825,508.00
210303	Цэвэр, бохир ус	3,265,893.00	2,089,659.09
2104	Хангамж, бараа материалын зардал	21,270,101.01	9,182,820.00
210401	Бичиг хэрэг	10,751,900.00	3,416,450.00
210402	Тээвэр, шатахуун	8,297,660.00	4,470,292.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	506,442.01	1,039,228.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	865,000.00	256,850.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210408	Бараа материал акгласны зардал	729,099.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,624,550.00	1,650,350.00
210604	Урсгал засвар	1,624,550.00	1,650,350.00
2107	Томиллолт, зочны зардал	3,108,200.00	-
210702	Дотоод албан томиллолт	3,108,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,153,800.00	44,997,900.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,153,800.00	44,530,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	434,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,519,576.93	136,670,272.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,177,700.00	18,048,200.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	82,827,002.00	74,018,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	38,514,874.93	44,603,672.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,781,218,740.10	3,153,770,849.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,628,629,746.00	3,022,653,642.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	817,652,346.00	1,096,340,642.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	2,793,432,000.00	1,739,962,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,545,400.00	186,351,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	152,588,994.10	131,117,207.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,567,154.10	131,117,131.13
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,840.00	76.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,643,096,929.71	4,255,794,028.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(28,241,168.86)	205,550,735.95
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(28,241,168.86)	205,550,735.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,588,118,527.00	4,277,376,528.60
1310	Улсын төсвөөс	4,447,824,800.00	3,860,134,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,447,824,800.00	3,860,134,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	140,293,727.00	417,242,528.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,090,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	91,218,127.00	324,325,028.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	22,256,600.00	42,749,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,729,000.00	50,168,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,840,885.00	95,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	1,840,885.00	95,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,840,885.00	95,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	67,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,773,685.00	95,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,589,959,412.00	4,277,471,528.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,593,777,727.00	4,281,257,484.93
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,558,986.90	1,107,515,678.77
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	578,750,799.90	785,980,213.09
210101	Үндсэн цалин	317,873,108.63	469,375,009.72
210102	Нэмэгдэл	160,563,184.19	206,748,380.29
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	48,388,197.58	58,144,029.97
210104	Урамшуулал	51,926,309.50	51,712,793.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,343,775.00	98,607,400.76
210201	Тэтгэврийн даатгал	50,501,175.00	68,566,365.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,460,700.00	7,734,894.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,730,300.00	4,352,944.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,730,300.00	3,870,782.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,921,300.00	14,082,413.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,303,300.00	32,008,919.92
210301	Гэрэл, цахилгаан	2,337,737.00	3,093,752.83

210302	Түлш, халаалт	29,699,670.00	26,825,508.00
210303	Цэвэр, бохир ус	3,265,893.00	2,089,659.09
2104	Хангамж, бараа материалын зардал	14,063,500.00	8,823,245.00
210401	Бичиг хэрэг	3,683,000.00	3,537,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,090,450.00	3,975,517.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,650.00	1,052,978.00
210404	Ном, хэвлэл	663,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,087,400.00	256,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,854,100.00	173,400.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210604	Урсгал засвар	3,854,100.00	173,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,108,200.00	-
210702	Дотоод албан томилолт	3,108,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,145,800.00	46,781,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,145,800.00	45,639,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	675,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	434,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,989,512.00	135,140,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,060,700.00	17,898,200.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	85,928,812.00	117,242,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,781,218,740.10	3,173,741,806.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,628,629,746.00	3,022,653,642.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	817,652,346.00	1,096,340,642.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	2,793,432,000.00	1,739,962,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,545,400.00	186,351,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	152,588,994.10	150,564,207.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	152,567,154.10	131,117,131.13
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,840.00	19,447,076.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	523,956.33
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	523,956.33
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	4,593,777,727.00	4,281,257,484.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(3,818,315.00)	(3,785,956.33)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,000.00	178,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	120,000.00	178,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	120,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	120,000.00	178,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	120,000.00	178,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(120,000.00)	(178,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(3,938,315.00)	(3,963,956.33)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,902,271.33	3,963,956.33
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,963,956.33	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	387,540,211.70	145,840,999.83	94,439,525.41	627,820,736.94
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(51,862,283.86)	(51,862,283.86)
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	387,540,211.70	145,840,999.83	66,453,356.55	599,834,568.08
19	Тайлант үеийн үр дүн	-	-	205,550,735.95	205,550,735.95
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	387,540,211.70	145,840,999.83	272,004,092.50	805,385,304.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	/төгрөгөөр/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татаас, санхүүжилтийн орлого	3,863,842,500.00	3,860,134,000.00	3,708,500.00
Улсын төсвөөс	3,863,842,500.00	3,860,134,000.00	3,708,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,863,842,500.00	3,860,134,000.00	3,708,500.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	858,521,800.00	733,795,029.29	124,726,770.71
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	758,905,800.00	733,795,029.29	25,110,770.71
Цалин	424,870,700.00	469,375,009.72	(44,504,309.72)
Цалингийн тусгай нэмэгдлүүд	334,035,100.00	264,420,019.57	69,615,080.43
Нийгмийн хамгааллын шимтгэл	99,616,000.00	92,171,232.66	7,444,767.34
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	83,691,700.00	78,088,818.83	5,602,881.17
Эрүүл мэндийн даатгалын хураамж	15,924,300.00	14,082,413.83	1,841,886.17
Бараа, үйлчилгээний урсгал зардал	32,976,000.00	32,008,919.92	967,080.08
Тогтмол зардал	32,976,000.00	32,008,919.92	967,080.08
Гэрэл цахилгааны зардал	5,140,600.00	3,093,752.83	2,046,847.17
Түлш, халаалтын зардал	24,919,300.00	26,825,508.00	(1,906,208.00)
Цэвэр, бохир усны зардал	2,916,100.00	2,089,659.09	826,440.91
Бусад бараа үйлчилгээний зардал	10,059,300.00	5,988,745.00	4,070,555.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	11,995,100.00	9,835,700.00	2,159,400.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	9,972,100.00	7,812,700.00	2,159,400.00
бараа үйлчилгээний зардал	2,023,000.00	2,023,000.00	-
Урсгал засварын зардал	173,400.00	173,400.00	-
Бусад зардал	23,086,000.00	149,858,331.13	(126,772,331.13)
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,927,030,900.00	2,836,302,642.00	90,728,258.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,863,842,500.00	3,860,134,000.00	3,708,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

	/төгрөгөөр/	
	Гүйцэтгэл	
Татаас, санхүүжилтийн орлого	367,074,528.60	
Урсгал	42,749,500.00	
Орон нутгийн төсвөөс	324,325,028.60	
Бараа, үйлчилгээний орлого	50,168,000.00	
Өмчийн орлого	367,074,528.60	
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	50,168,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	417,242,528.60	
Ажиллагчидтай холбогдсон зардал	58,621,351.90	
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	52,185,183.80	
Цалин	52,185,183.80	
Нийгмийн хамгааллын шимтгэл	6,436,168.10	

Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	6,436,168.10
Бусад бараа үйлчилгээний зардал	2,834,500.00
Бичиг хэргийн материал	834,500.00
Тээвэр, шатахууны зардал	2,000,000.00
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	121,864,900.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	109,429,700.00
бараа үйлчилгээний зардал	12,435,200.00
Бусад зардал	47,570,776.70
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	186,351,000.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	417,242,528.60

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,983.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, завсрын аудитаар 1,639.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн, жилийн эцсийн аудитаар 36,800.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,544.5 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж тус тус хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 36,800.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Төрөлжсөн сургалтын 36,800.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн урамшуулал олгосон боловч Дундговь аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны Б/67 тоот тушаалаар Өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр нягтлан бодогчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,559.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна*" гэж заасантай нийцээгүй, нийцсэн ба зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансын урамшууллыг хууль тогтоомж зөрчиж авсан этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

3.2.1 Техник технологийн олимпиадын шүүгчээр ажилласан 4 хүнд 2025 оны 3 сарын 21-нд 800.0 мянган төгрөгийн төлбөрийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу шилжүүлэхдээ холбогдох татварыг суутгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6-д "*үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа хувь хүнээс холбогдох татварыг суутгах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

3.2.2 Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 оны 159 тоот "Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон" албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, балансын урамшууллыг олгож зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил гаргасан этгээдэд сахилгын шийтгэл ногдуулах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

3.3.1 2025 оны 12 сарын 24-ний өдрийн мөнгөн зарлагын гүйлгээнд 204.7 мянган төгрөгийн сугалааны дугаартай НӨАТ-ын баримт хавсаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн

3.3.2 Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 2,339.8 мянган төгрөгийн 2 ширхэг хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", Сангийн сайдын "Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалын хавсралт "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг залруулж ангилал зөв бүртгэх зөвлөмж өгөх

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 10.2 хувийг залруулагдаагүй, 89.8 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 4,183.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 4,103.5 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын 3 зөрчил, 80.0 мянган төгрөгийн нийцлийн аудитын 2 зөрчил байна. Үүнээс завсрын аудитаар илэрсэн 1,559.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдуулж, 80.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан учраас дүгнэлтийн материаллаг байдалд нөлөөлөхгүй. Харин жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй,

аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,544.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 40,013.4 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрөлжсөн сургалтын авлагыг бүртгэлд тусгаагүй байна.	1	36,800.0	1	36,800.0	-	-	1	36,800.0	-	-
Дүн	1	36,800.0	1	36,800.0	-	-	1	36,800.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн урамшуулал олгосон боловч Дундговь аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны Б/67 тоот тушаалаар Өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр нягтлан бодогчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх балансын урамшууллыг давхардуулан олгосон байна.	1	1,559.0	1	1,559.0	-	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 24-ний өдрийн ажил гүйлгээнд сугалааны дугаартай НӨАТ-ын баримт хавсаргасан байна.	1	204.7	-	-	-	-	1	204.7	-	-
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 ширхэг хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1	2,339.8	-	-	-	-	1	2,339.8	-	-
Дүн	3	4,103.5	1	1,559.0	-	-	2	2,544.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Техник технологийн олимпиадын шүүгчээр ажилласан 4 хүнд 2025 оны 3 сарын 21-нд төлбөрийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу шилжүүлэхдээ холбогдох татварыг суутгаж тайлагнаагүй байна.	1	80.0	-	-	1	80.0	-	-	-	-
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 оны 159 тоот "Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон" албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, балансын урамшууллыг олгож зөрчлийг давтан гаргасан байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	2	80.0	-	-	1	80.0	-	-	1	-